



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

**Даланзадгад
2020 он**

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2020 ОНЫ ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1. Бодлогын зорилтыг хангах талаар

- 1.1. Удирдлага зохион байгуулалт
- 1.2. Тайлан мэдээ, албан бичиг
- 1.3. Санхүү, үнэт цаасны тооцоо, тайлан мэдээ

2. Иргэний улсын бүртгэл

- 2.1. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл
- 2.2. Гадаадад зорчих эрхийн бүртгэл
- 2.3. Иргэний биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл болон иргэний үнэмлэхний бүртгэл
- 2.4. Иргэний улсын бүртгэлийн архивийн лавлагаа, тайлан мэдээ

3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл

- 3.1. Иргэн, хуулийн этгээдийн өмчлөх эрхийн баталгаажуулалт, өөрчлөлт, түүнтэй холбоотой бусад эрхийн бүртгэл, лавлагаа, тайлан мэдээ
- 3.2. Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн бүртгэл
- 3.3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх мэдээллийн сан, нотлох баримтаар хувийн хэрэг бүрдүүлж, иргэн, хуулийн этгээд болон хууль хяналтын байгууллагыг ЭХЭУБүртгэлийн архивын лавлагаа, мэдээллээр хангах чиглэлээр

4. Хуулийн этгээдийн улсын бүртгэл

- 4.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн архивын лавлагаа, мэдээлэл, тайлан мэдээ

5. Програм хангамжийн талаар

6. Улсын бүртгэлийн хяналт шалгалт

- 6.1 Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр
- 6.2 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр
- 6.3 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр
- 6.4 Бусад ажил үйлчилгээ

7. Удирдлагын багт тавих санал

8. 2021 оны зорилт

БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХАНГАХ ТАЛААР

1.1 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь УБЕГазрын даргын 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн Б/07 тоот тушаалаар батлагдсан орон тооны дагуу 2020 онд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 1, хяналтын улсын байцаагч 1, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 2, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 2, иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 2, хуулийн этгээдийн улсын бүртгэгч 1, архивч 2, ахлах нягтлан бодогч 1, нярав, мэдээллийн технологийн ажилтан 1, Архив, бичиг хэргийн ажилтан 1, гэрээт албан хаагч үйлчлэгч 2, жижүүр 2, 15 сумын 14 улсын бүртгэгч нийт 31 албан хаагчтайгаар Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон орон нутгийн удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, удирдамж чиглэл, тушаал, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч бүртгэлийг хөтлөн хэрэгжилтийг өдөр тутмын ажил, үйлчилгээнд бүрэн хэрэгжүүлж, иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг орон нутагт эрхлэн зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн Улсын бүртгэлийн үйлчилгээг үнэн зөв, ил тод, түргэн шуурхай, шударга, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэн үйлчиллээ.

МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ.

➤ 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр аймгийн ГХБХБ-ын газрын удирдлага, мэргэжилтэнүүдтэй Даланзадгад сумын ИТХурлын баталсан хаягын тогтоолыг хэрхэн хэрэгжүүлэх, сумдын газрын даамлуудаас ирүүлж байгаа газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн нотлох баримтад анхаарах асуудлын талаар ойлголтын зөрүүг арилгах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

➤ 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр УБЕГазраас орон нутаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн сумын улсын бүртгэгч нарыг “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах” арга зүйгээр хангахад чиглэсэн онлайн сургалтанд хэлтсийн төрийн захиргааны бүх албан хаагчид хамрагдсан.

➤ 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдөр УБЕГазрын ИУБГазраас зохион байгуулж буй Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сонгуулийн тухай хууль тогтоомжийг таниулах, зөвлөмж чиглэл өгөх зорилготой онлайн сургалтанд Хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Д.Насантуяа, ИУБТасгийн улсын бүртгэгч З.Хасар, Б.Баясгалан, Нярав, Мэдээллийн технологийн ажилтан О.Эрдэнэбат нар хамрагдсан.

➤ 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Олон улсын хэрэглэгчийн өдрийг тохиолдуулан “Улсын бүртгэлийн үйлчилгээ” холбогдох хууль, журмын талаар олон нийтийн цахим сүлжээгээр иргэдэд мэдээлэл хүргэсэн.

➤ 2020 оны 03 дугаар сарын 23-нд УБЕГазрын ЭХЭУБГазраас зохион байгуулж буй Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхөд гарч буй нийтлэг алдаа, зарим системийн боловсруулалтанд анхаарах асуудлуудын талаар зөвлөмж, чиглэл өгөх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой онлайн сургалтанд Хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг, ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал, ЭХЭУБТасгийн улсын бүртгэгч М.Оюун-Эрдэнэ, Т.Нямсамбуу, архивч А.Цэцэгдэлгэр нар хамрагдсан.

➤ 2020 оны 04 дүгээр сарын 15, 16 ны өдрүүдэд Улсын бүртгэлийн дотоод үйл ажиллагааг шуурхай, нэгдсэн удирдлагаар хангах, цаг үеийн нөхцөл байдлын талаар санал, мэдээлэл солилцох, орон нутаг дахь газар, хэлтсийн удирдлагуудад үүрэг, чиглэл, зөвлөмж өгөхөд чиглэсэн удирдах ажилтны онлайн сургалтанд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Энхмөнх, Хяналтын улсын байцаагч

Д.Наранбилэг, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Д.Насантуяа, ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал, Хуулийн этгээдийн улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Должинсүрэн, Мэдээллийн технологийн ажилтан О.Эрдэнэбат нар оролцож мэдээлэл солилцсон.

➤ 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр УБЕГазар болон орон нутаг дахь газар, хэлтсийн албан хаагчдыг мэргэшүүлэх, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй эрх зүйн актуудыг хэрэгжүүлэхэд анхаарах зөвлөмж, чиглэл өгөх зорилготой онлайн сургалтанд Архив, бичиг хэргийн ажилтан Ч.Пүрэвдавга хамрагдаж мэдээлэл авсан.

➤ 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр “Иргэний улсын бүртгэлийн систем”-ийн нэвтрүүлэлтийн төлөвлөгөөг танилцуулах, иргэний улсын бүртгэлийн системийн туршилтыг хэрхэн гүйцэтгэх тухай танилцуулга зөвлөмж, иргэний улсын бүртгэлийн зарим бүртгэл хөтлөлтөнд анхаарах асуудлын талаар зөвлөмж өгөх онлайн сургалтанд хэлтсийн дарга Ч.Энхмөнх, ИУБТасгийн албан хаагчид бүрэн хамрагдсан.

➤ 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр УБЕГазрын сургалтын төлөвлөгөөний дагуу Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарт зориулсан онлайн сургалтанд Хуулийн этгээдийн улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Должинсүрэн, хэлтсийн дарга Ч.Энхмөнх нар хамрагдсан.

➤ 2020 оны 05 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих, тэдгээрийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг өгөх онлайн сургалтанд Хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг хамрагдаж албан хаагчдад мэдээлэл хүргэсэн.

➤ 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутаг дахь Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудыг хууль эрх зүйн мэдээллээр хангах, тэдэнтэй гэрээ байгуулахад анхаарах асуудлаар харъяа нэгжийн удирдлагуудад чиглэл зөвлөмж өгөх онлайн сургалтанд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, Хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг, ИУБТасгийн албан хаагчид, Даланзадгад сумын улсын бүртгэгч С.Ариунсайхан, ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал нар хамрагдаж албан хаагчдад мэдээ, мэдээлэл өгсөн.

➤ УБЕГазрын дэд даргын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу Өмнөговь аймгийн УБХэлтэс нь 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдөр УИХ-ын 11-р тойргийн 61 хэсэгт ажиллах 70 итгэмжлэгдсэн ажилтан, шуурхай багийн 4 албан хаагчдад хууль эрх зүйн сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулсан.

➤ 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Насан туршийн боловсролын төвөөс “Угийн бичиг хөтлөх” хэрэгцээ, шаардлага, хөтлөх аргачлалын талаар сургалт авч хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдсан.

➤ 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Засгийн газрын “Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай” 01 дүгээр албан даалгаврыг 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Хүүхдийн эрхийн хамгааллын асуудлаар мэдээлэл өгөх зорилготой онлайн сургалтанд Хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг, ЭХЭУБТасгийн ахлах бүртгэгч Б.Азжаргал, ИУБТасгийн ахлах бүртгэгч Д.Насантуяа “Хүүхэд гэр бүлийн хөгжлийг дэмжих зөвлөл” оролцсон.

➤ 2020 оны 05 дугаар сарын 26-ны өдөр УБЕГазрын 2020 оны сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, албан хаагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцлийг арилгахад шаардлагатай мэдээ, мэдээлэл өгөх зорилготой онлайн сургалтанд Хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Д.Насантуяа, ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал нар хамрагдаж алба хаагчдад мэдээлэл өгч ажилласан.

➤ Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргын 2020 оны 06 сарын 02-ны өдөр баталсан Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудын дунд зохион байгуулагдах ирц бүртгэлийн программын сургалтын үед хийгдэх үйл ажиллагааны удирдамжийн дагуу Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн даргын баталсан хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 06 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн 11 дүгээр тойргийн 61 хэсгийн хорооны санал авах санал авах байрны дэргэд ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтануудад 2 өдрийн сургалтыг бүрэн зохион байгуулсан.

➤ 2020 оны 08 дугаар сарын 11 нд УБЕГазрын Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан ЭХЭУБүртгэлийн талаарх онлайн сургалтанд Хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг, ЭХЭУБТасгийн албан хаагчид бүрэн хамрагдсан.

➤ 2020 оны 08 дугаар сарын 22-ны өдөр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон орон нутаг дахь хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарт хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг тогтоох, мэдээллийг улсын бүртгэлд бүртгэхэд тулгамдаж буй асуудлаар нэг мөр ойлголт өгөх, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, мэдээлэлээр хангах зорилготой сургалтыг зохион байгуулж Хуулийн этгээдийн улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Должинсүрэн хамрагдсан.

➤ 2020 оны 09 дүгээр сарын 10 нд Ёс зүйн хорооноос зохион байгуулсан “Төрийн албаны шинэтгэл-Ёс зүй хандлага” сэдэвт online сургалтанд хамрагдсан.

➤ УБЕГазрын дэд даргын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу Өмнөговь аймгийн УБХэлтэс нь 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр АНСДИТХурлын 14 дүгээр тойргийн 61 хэсэгт ажиллах 61 итгэмжлэгдсэн ажилтан, 4 албан хаагчдад хууль эрх зүйн сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулсан.

➤ 2020 оны 09 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд Удирдлагын академаас зохион байгуулсан “Төрийн байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ” сэдэвт сургалтанд ИУБүртгэлийн улсын бүртгэгч Ч.Пүрэвдавга 16 цагийн хичээл судалж №20/0972 дугаартай үнэмлэх авсан.

➤ Аймгийн ЗДТГазрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс зохион байгуулсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулах нь” сургалтыг 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Должинсүрэн, ИУБТасгийн улсын бүртгэгч Ч.Пүрэвдавга нар сургалтанд бүрэн хамрагдсан.

➤ Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга болон Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн даргын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу Өмнөговь аймгийн УБХэлтэс нь 2020 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн итгэмжлэгдсэн ажилтанг хууль эрх зүйн мэдлэгээр хангах, сонгогчийн бүртгэлийг тулган шалгах, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг таньж оруулах, техник хэрэгсэл, программ хангамжтай ажиллах дадлага олгох сургалтыг 14 дүгээр тойргийн 61 хэсэгт ажиллах 61 итгэмжлэгдсэн ажилтан, шуурхай багийн 5 албан хаагчдад танхимаар сургалт зохион байгуулсан.

➤ "Улсын бүртгэлийн байгууллагын үүсэж хөгжсөний түүхт 80 жил"-ийн ойн арга хэмжээг тохиолдуулан 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь Эрүүл мэндийн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтарч "Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудал" сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан.

➤ Улсын бүртгэлийн нэгдсэн архиваас Иргэний улсын бүртгэлийн лавлагааг олгоход цахим архивыг хэрхэн ашиглах, лавлагаа олгох аргачлалыг иргэний улсын бүртгэгч нарт зааж, мэдээлэл өгөх зорилготой сургалтыг 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулж Даланзадгад сумын 2 улсын бүртгэгч, ИУБТасгийн улсын бүртгэгчид бүрэн хамрагдсан.

ЦАГ ҮЕИЙН АЖИЛ

➤ 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Улсын бүртгэлийн хэлтсийн "Үйлдвэрчиний эвлэлийн хороо" 32 албан хаагчдад амны хаалт, дархлаа дэмжих Vitagripp витамин, Салимон бэлдмэл өгч, вирусээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан. Албан хаагчдыг халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс хэлтсийн ҮЭвлэлийн хорооноос 958 000 төгрөгөөр 2 удаа амны хаалт, витамин, ариутгалын материалаар хангаж ажилласан.

➤ 2020 оны 03 дугаар сарын 16 ны өдөр "Олон улсын хэрэглэгчдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг угтан улсын бүртгэлийн үйлчилгээний цаг үеийн мэдээ, мэдээллийг олон нийтийн сүлжээгээр иргэдэд хүргэж ажилласан.

➤ Шинэ төрлийн коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор үйлчилгээний танхимд 2 метрийн зайнаас үйлчлүүлэх тэмдэг тэмдэглэгээг нааж иргэдэд мэдээлэл өгч ажиллаж байна.

➤ Үйлчилгээний танхимд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч, Иргэний улсын бүртгэлчийн үйлчилгээний цонхонд иргэд үйлчилгээ авах дугаар бүхий шилэн сав байршуулж, шалан дээр **!!!COVID 19 !!! 1-2 метр** зай барь гэсэн 10 тэмдэглэгээг нааж, иргэдэд зохих ёсны шаардлага тавьж, албан хаагчид болон иргэдийг мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна.

➤ 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр аймгийн ЭМГазрын Зоонозын өвчин судлалын төвөөр хэлтсийн 1134 м.кв талбайд ариутлгал хийлгэж ажилласан.

➤ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу цаг тухай бүр сонгуулийн бэлтгэл ажлын талаар ажил арга хэмжээг зохион байгуулсан ажилласан.

➤ Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойг угтаж 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдөр хамтран ажилладаг 12 төрийн байгууллагуудын дунд зохион байгуулсан "Ширээний теннис"-ний тэмцээн, мөн 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр "Гар бөмбөгийн тэмцээн"-ийг тус тус амжилттай зохион байгуулсан.

➤ Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 80 жилийн ойг тохиолдуулан Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсээс иргэд, хуулийн этгээдэд чиглэсэн бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 14 суманд хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэлийн талаарх мэдээлэл өгч, бүрдүүлбэр материалыг хүлээн авч ажилласан.

➤ Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд тус хэлтсээс зохион байгуулсан "УЛСЫН БҮРТГЭЛ - 80 ЖИЛ" сэдэвт гар зургийн уралдаан, "ХОС БИЧИГТЭН" сэдэвт уралдаанд ерөнхий боловсролын сургуулийн сурагч, багш, малчин, эмч, төрийн албан хаагчид гээд нийт 15 сумын 60 гаруй иргэний бүтээлүүд ирж шилдгүүдийг шалгаруулж, шалгарсан бүтээлээр А5 хэмжээтэй 8 хуудас нь 2 талтай 2021 оны календарь 100 ширхэгийг хэвлүүлж аймаг, сумдын удирдлагын баг, хамтран ажилладаг байгууллага, ахмад албан хаагч, албан хаагчидад дурсгал болгон өгсөн.

➤ 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдөр аймгийн ЭМГазрын Зоонозын өвчин судлалын төвөөр хэлтсийн 1134 м.кв талбайд ариутгал хийлгэж ажилласан.

АЙМАГ, ОРОН НУТГИЙН УДИРДЛАГАТАЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ:

✓ 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Энхмөнх Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25.1 дэх заалт: Иргэний шилжилт хөдөлгөөнийг сонгуулийн жилийн 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс түр зогсоох тухай мэдээллийг орон нутгийн телевиз болон сайтаар иргэдэд мэдээлэл хүргэсэн.

✓ Шинэ төрлийн коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор Төрийн байгууллагын алба хаагчдыг 24 цагийн постод гаргаж өндөржүүлсэн бэлэн байдалд

ажиллаж байна. Улсын бүртгэлийн “Иргэний бүртгэлийн мэргэжлийн анги” 2020 оны 03 дугаар сарын 03 дугаар сарын 13 ний өдрийн 18.00 цагаас 14-ний өдрийн 18.00 цагийн хооронд Ханхонгор сумын постонд гарч дараагийн байгууллагад хүлээлгэн өгч ажилласан.

✓ ЭМЯам болон аймгийн Эрүүл мэндийн газраас цаг тухай бүр ирүүлж байгаа заавар, зөвлөмжийг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж, ажилчид, албан хаагчид, үйлчлүүлэгчид мэдээ, мэдээлэл түгээж, ариутгах бодис, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг шаардлага түвшинд авч ажиллаж байна.

✓ Улсын бүртгэлийн багц хуулиуд хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “Эрх зүйч” мэргэжилгүй албан хаагчдыг “Эрх зүйч мэргэжитэй болгох зорилгоор 2018 оны 02 дугаар сарын 05 ны өдөр Шихихутуг их сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хөгжүүлэх “Бид хамтдаа хөтөлбөр”-ийн 152 дахь заалтын хүрээнд “Чадварлаг албан хаагч-Чанартай гүйцэтгэл” зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргад хэлтсийн “Эрх зүйч” мэргэжлээр суралцаж байгаа 12 албан хаагчдын сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх асуудлыг судлаж дэмжлэг үзүүлэх хүсэлт хүргүүлэн шийдвэрлүүлж албан хаагч бүрт 3000000 /гурван сая/ төгрөгний дэмжлэг авч нийт 36000000 /гучин зургаан сая/ төгрөгийг шийдвэрлүүлж 2020 оны 05 дугаар сарын 29 ний өдөр 14 албан хаагч “Эрх зүйч” мэргэжлийн баклавын диплом, ромбоо гардан авсан.

✓ Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хөгжүүлэх “Бид хамтдаа хөтөлбөр”-ийн 153 дахь заалтын хүрээнд Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, тусламж, дэмжлэг үзүүлэх асуудлын хүрээнд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч М.Энхтогтох, хэлтсийн дарга Ч.Энхмөнх нарт орон сууцны зээлд дэмжлэг үзүүлэх тухай аймгийн Засаг даргад хүсэлт хүргүүлсний дагуу тус бүрд 5000000 /таван сая/ төгрөгний дэмжлэг авсан.

✓ Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хөгжүүлэх “Бид хамтдаа хөтөлбөр”-ийн 158 дахь заалтын хүрээнд "Зөгийн үүр" дэд хөтөлбөрийн хүрээнд Тайвань улсын Нанхуа их сургуулийн Төрийн удирдлагын магистрын тэтгэлэгт сургалтын шалгалтанд Даланзадгад сумын улсын бүртгэгч Б.Должинсүрэн тэнцэж

Тайвань улсад 2 жил суралцаж төгсөж ирээд ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна.

✓ Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хөгжүүлэх “Бид хамтдаа хөтөлбөр”-ийн 159 дэх заалтын хүрээнд 2020 онд Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/264 дугаар захирамжаар Хэлтсийн барилгын дээврийн засварын ажлыг “Хөрхдөр хан” ХХКомпаниар 31000006 /гучин нэгэн сая зургаа/ төгрөгний ажлыг хийлгэж 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр бүрэн дуусгаж комисст хүлээлгэж өгч ажилласан.

✓ Өмнөговь аймгийг 3 жил дараалан Монгол Улсын “Шилдэг аймаг” болсныг батламжилсан 3 цомыг Улсын бүртгэлийн хэлтэс хүлээн авч, “Танд баярлалаа” булан байгуулж Улсын бүртгэлийн ажил, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажилласан.

✓ 2020 оны 07 дугаар сарын 10 ны өдрөөс 08 дугаар сарын 20 ны өдрүүдэд хэлтсийн албан хаагчидаас 2020 оны ээлжийн амралтаа авсан 9 албан хаагчийг Говь-Алтай, Завхан, Увс, Баян-Өлгий, Ховд, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймагт аялах, дээрх аймгуудийн Улсын бүртгэлийн хэлтсийн ажил, үйлчилгээтэй танилцуулж, туршлага судлах ажлыг зохион байгуулсан.

✓ 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр “Өрх гэр бүлийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Мэдээллийн технологийн ажилтан, нярав О.Эрдэнэбатад хувийн орон сууц барихад дэмжлэг үзүүлж орон нутгаас 10000000 /арван сая/ төгрөгний дэмжлэг үзүүлэн ажилласан.

✓ Аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/1190 дугаар захирамжаар Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдах улсын чанартай спортын уралдаан тэмцээний зардалд 11000000 /арван нэгэн сая/ төгрөгний дэмжлэг үзүүлсэн.

✓ Аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/1321 дугаар захирамжаар Улсын бүртгэлийн хэлтэст шаардлагтай тоног, төхөөрөмж “Эрдэнэт хуудас” ХХКомпани 9900000 /есөн сая есөн зуун мянган төгрөг/-ний үнэ бүхий Epson WorkForce DS-530 маркын скайнер Epson WorkForce DS-780 маркын скайнер тус бүр 2 ширхэгийг хүлээлгэн өгсөн.

✓ Даланзадгад сумын Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/230 дугаар захирамжаар Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд дэмжлэг

үзүүлж 10000000 /арван сая/ төгрөгний үнэ бүхий Dell Inspiron маркын 3 ширхэг зөөврийн компьютер шийдвэрлэсэн.

✓ Монгол улсад бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 80 жилийн ойг тохиолдуулан 2020 оны 11 дүгээр сарын 05, 06-ны өдрүүдэд Ханбогд сумын ЗДТГазартай хамтран “Улсын бүртгэлийн өдөрлөг”-ийг зохион байгуулж, 250 гаруй иргэн, хуулийн этгээдэд ЭХЭУБ-ийн үйлчилгээг газар дээр нь хүргэж өмчлөх эрхийн 59 гэрчилгээг газар дээр нь олгож, ажил үйлчилгээгээ сурталчилан танилцуулж, иргэдэд бүртгэлийн үйлчилгээг орон зай, цаг хугацааны бодит хэмнэлттэй хүргэж үйлчилсэн.

✓ 2020 оны 11 дүгээр сарын 05 өдөр Ханбогд суманд 3х3 сагсан бөмбөмгийн тэмцээнийг хамтран ажилладаг төрийн байгууллагуудын албан хаагчдын дунд зохион байгуулж, 2020 онд 16 нас хүрсэн Ханбогд сумын 60 хүүхдэд “Монгол улсын иргэний андгай өргөх ёслол”-ыг Ханбогд сумын ЗДТГазар, МЗХолбоо, 1, 2 дугаар сургуулийн захиргаатай хамтран зохион байгуулсан.

✓ Аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/1384 дугаар захирамжаар хяналт шалгалтын зардалд 2737000 /хоёр сая долоон зуун гучин долоон мянга/ төгрөгийг шийдвэрлэсэн.

✓ Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахалаас урьдчилан сэргийлэх зорилгоор улсын онцгой комисс, аймгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 01-ний хугацаанд хуваарийн дагуу постонд 24 цагаар албан хаагчид үүрэг гүйцэтгэсэн.

✓ Өмнөговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас “Өрх гэр бүлийн хөгжлийн жил”-ийн хүрээнд байгууллагынхаа гэр бүл, үр хүүхдэд чиглэсэн арга хэмжээ, сургалт, нөлөөллийн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулсан хэлтсийн “Хүүхэд, гэр бүлийн хөгжлийг дэмжих зөвлөл” аймгийн хэмжээнд 3 дугаар байр эзэлж, Өргөмжлөл, 450 000 төгрөгөөр шагнагдсан.

✓ 2020 оны 11 дүгээр сарын 22-27-ны өдрүүдэд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Өмнөговь аймгийн Засаг дарга, Онцгой комисс, УБЕГазартай хамтран Өмнөговь аймгийн Гашуун сухайт, Шивээ хүрэн боомтоор нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 70 гаруй компанийн 348 жолооч нарын гадаад паспортын асуудлыг шуурхай шийдвэрлэсэн ажилласан.

✓ Монгол Улсын шадар сайдын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 146 дугаар тушаалаар батлагдсан “Зорчигч тээврийн үйлчилгээг зохион байгуулах

түр журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн онцгой комиссын Шуурхай штабын “Иргэдийг хүлээн авах бүртгэл, хяналтын бүлэг”-т орж 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл хугацаанд 24 цагаар алба хаагчид үүрэг гүйцэтгэж ажилласан.

БОЛОВСОН ХҮЧНИЙ ТАЛААР:

Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь Хэлтсийн дарга 1, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 2, хяналтын улсын байцаагч 1, улсын бүртгэгч 19, Ахлах нягтлан бодогч 1, Архивч 2, Нярав, мэдээллийн технологийн ажилтан 1, үйлчлэгч 1 /гэрээт албан хаагч/, жижүүр 3 /гэрээт албан хаагч/, нийт 31 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

➤ Хэлтсийн даргын 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн Б/01 тоот тушаалаар хэлтсийн Архив, бичиг хэргийн ажилтны албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Б.Должинсүрэнг томилсон.

➤ Хэлтсийн даргын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Б/02 тоот тушаалаар ахлах нягтлан бодогч С.Батхүүг үүрэгт ажлаас чөлөөлж, 2020 оны 02 дугаар сарын 21 ний өдөр М.Заяаг туршилтын 6 сарын хугацаагаар Ахлах нягтлан бодогчоор Б/03 дугаар тушаалаар томилсон.

➤ Хэлтсийн даргын 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Б/04 дугаар тушаалаар Архив, бичиг хэргийн ажилтны албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Должинсүрэнг үүрэгт ажлаас нь чөлөөлж, Ч.Пүрэвдавгын хүүхэд асрах чөлөөг дуусгавар болгож Б/05 дугаар тушаалаар Архив, бичиг хэргийн үүрэгт ажилд томилсон.

➤ УБЕГазрын даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Б/161 дугаар тушаалаар хуулийн этгээдийн улсын бүртгэгч М.Энхтогтоход жирэмсний амралт олгож, Б.Должинсүрэнг хуулийн этгээдийн улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон.

➤ Хэлтсийн даргын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Б/06 дугаар тушаалаар ЭХЭУБТасгийн архивчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Цэцэгдэлгэрийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, А.Цэцэгжаргалын хүүхэд асрах чөлөөг дуусгавар болгож Б/07 дугаар тушаалаар Архивчийн үүрэгт ажилд томилсон.

➤ Хэлтсийн даргын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Б/08 дугаар тушаалаар ИУБТасгийн архивч Т.Хандсүрэнд хүүхэд асрах чөлөө олгож,

А.Цэцэгдэлгэрийг Б/09 дүгээр тушаалаар ИУБТасгийн архивчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон.

➤ Хэлтсийн даргын 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн Б/10 дугаар тушаалаар туршилтын хугацаагаар ажиллаж байсан Ахлах нягтлан бодогч М.Заяаг үүрэгт ажлаас нь чөлөөлж, С.Батхүүг Б/11 дүгээр тушаалаар Ахлах нягтлан бодогчийн үүрэгт ажилд томилсон.

➤ УБЕГазрын даргын 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн Б/305 дугаар тушаалаар Хүрмэн сумын улсын бүртгэгч томилогдох хүртэл хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр С.Солонгыг томилсон.

➤ УБЕГазрын даргын 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн Б/335 дугаар тушаалаар Ханхонгор сумын улсын бүртгэгч Ц.Мөнхдалай үүрэгт ажлаас чөлөөлсөн.

➤ Хэлтсийн даргын 2020 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн Б/12 дугаар тушаалаар жижүүр С.Байгальмааг чөлөөлж, Б.Хадбаатарыг 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн Б/13 дугаар тушаалаар жижүүрийн үүрэгт ажилд томилсон.

➤ УБЕГазрын даргын 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн Б/440 дүгээр тушаалаар Булган сумын улсын бүртгэгч томилогдох хүртэл хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр Г.Тогтохсүрэнг томилсон.

➤ Хэлтсийн даргын 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн Б/14 дүгээр тушаалаар жижүүр Ө.Байгальмааг чөлөөлсөн. Хэлтсийн даргын 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн Б/15 дугаар тушаалаар Архив, бичиг хэргийн ажилтан Ч.Пүрэвдавгыг үүрэгт ажлаас чөлөөлж, Г.Мөнхнасанг 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн Б/16 дугаар тушаалаар Архив, бичиг хэргийн ажилтны үүрэгт ажилд томилсон.

➤ УБЕГазрын даргын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн Б/458 дугаар тушаалаар хуулийн этгээдийн улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Должинсүрэнг үүрэгт ажлаас чөлөөлж, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Д.Насантуяад жирэмсний амралт олгож, Б.Должинсүрэнг ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон.

➤ УБЕГазрын даргын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн Б/459 дугаар тушаалаар хуулийн этгээдийн улсын бүртгэгч М.Энхтогтохын хүүхэд асрах чөлөөг дуусгавар болгон үүрэгт ажилд нь үргэлжлүүлэн ажлуулсан.

➤ УБЕГазрын даргын 2020 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн Б/480 дугаар тушаалаар ИУБТасгийн улсын бүртгэгч Б.Баясгаланг үүрэгт ажлаас чөлөөлж, 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн Б/488 дугаар тушаалаар ИУБТасгийн улсын бүртгэгч томилогдох хүртэл хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр Ч.Пүрэвдавгыг томилсон.

➤ Хэлтсийн даргын 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Б/17 дугаар тушаалаар Б.Хадбаатарыг чөлөөлж, Х.Энхбайгалийг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Б/18 дугаар тушаалаар жижүүрийн үүрэгт ажилд томилсон.

➤ УБЕГазрын даргын 2020 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн Б/480 дугаар тушаалаар ИУБТасгийн улсын бүртгэгч Б.Баясгаланг үүрэгт ажлаас чөлөөлж, 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн Б/488 дугаар тушаалаар ИУБТасгийн улсын бүртгэгч томилогдох хүртэл хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр Ч.Пүрэвдавгыг томилсон.

➤ УБЕГазрын даргын 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн Б/521 дүгээр тушаалаар Баяндалай сумын улсын бүртгэгч Б.Сүрэнхүүг төрийн албанаас чөлөөлсөн.

➤ Хэлтсийн даргын 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн Б/19 дүгээр тушаалаар жижүүр Д.Баттөрийг жижүүрийн үүрэгт ажилд томилж, 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар жижүүр Х.Энхбайгалийг жижүүрийн үүрэгт ажлаас чөлөөлсөн.

➤ Хэлтсийн даргын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Б/21 дүгээр тушаалаар С.Дарьмааг үйлчлэгчийн үүрэгт ажилд томилсон.

➤ Хэлтсийн даргын 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Б/22 дугаар тушаалаар Г.Мөнхнасанг архив, бичиг хэргийн ажилтны үүрэгт ажлаас чөлөөлсөн.

➤ Хэлтсийн даргын 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Б/23 дугаар тушаалаар Д.Мэнджаргалыг жижүүрийн үүрэгт ажилд томилсон.

➤ УБЕГазрын даргын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Б/603 дугаар тушаалаар Номгон сумын улсын бүртгэгч Э.Пүрэвийг төрийн албанаас чөлөөлсөн.

ТАЙЛАН МЭДЭЭ, АЛБАН БИЧГИЙН ТАЛААР:

2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар Улсын бүртгэлийн хэлтэст 897 албан бичиг ирсэнийг зохих журмын дагуу бүртгэн авч холбогдох ажилтнуудад шилжүүлэн биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа. 423 хариутай албан бичиг ирснээс хариуг тухай бүрт нь шийдвэрлүүлэн холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Мөн тайлангийн хугацаанд 1062 албан бичиг зохих стандарт, журмын дагуу боловсруулан холбогдох албан байгууллага, иргэдэд хүргэж ажиллаа.

Улсын бүртгэлийн хэлтэст 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар иргэдээс нийт 157 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирсэнээс 113 өргөдөлийг шийдвэрлэн холбогдох албан тушаалтан, иргэдэд хариуг хүргүүлэж, 1 өргөдөл гомдол, санал хүсэлтийг холбогдох байгууллагуудад шилжүүлэн шийдвэрлэлтэнд хяналт тавьж, холбогдох газарт цаг тухай бүр хүргүүлэн ажилласан.

1. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. Төсвийн зарцуулалт: 2020 оны хагас жил, улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд УБЕГГазрын Санхүү, төлөвлөлтийн газарт хүргүүлэн ажилласан. Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүр холбогдох тодруулгын хамт Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүү, төлөвлөлтийн газарт хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

2020 оны 11-р сарын байдлаар үйлчилгээний орлогын төлөвлөгөө 183 000 000 /Нэг зуун наян гурван сая/ төгрөг. Үүнээс 2020 оны 11 сарын байдлаар 160 518 582 /нэг зуун жаран сая таван зуун арван найман мянга таван зуун наян хоёр / төгрөг төвлөрүүлэн ажилласан байна.

2020 оны 01 дүгээр сарын 25-ний өдөр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Аймгийн Төрийн аудитын газраар шалгуулж “Зөрчилгүй” дүгнэлт авсан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн мэдээллийг сар бүрийн 8-ны өдрийн дотор 14 үзүүлэлтээр бүрэн гаргаж байршуулан, 3 дүгээр улирлын тайланг илгээсэн.

2. Үйлчилгээний хураамж, үйл ажиллагааны орлого: Иргэний бүртгэлийн үйлчилгээний хураамж 210000089483 тоот дансанд, эд хөрөнгийн үйлчилгээний хураамж 210000093088 тоот дансанд, цахим үнэмлэхний үнэ 210000258471 тоот дансанд тус тус тушаалган Өмнөговь аймгийн Төрийн сангийн 100110012008 тоот

дансанд төвлөрүүлэн, улмаар сар бүрийн 25-ны дотор Улсын төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна.

3. Бараа материал, үндсэн хөрөнгө: Иргэний бүртгэлийн 21 төрөл, Эд хөрөнгийн бүртгэлийн 3 төрөл, Хуулийн этгээдийн 3 нийт 27 төрлийн үнэт цаас ашиглагдаж байгааг УБЕГазраас хөрөнгийн санхүүжилтээр авч нөөцийг бүрэн ханган ажиллаж байна.

2. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ

НЭГ. БОДЛОГЫН ЗӨВЛӨГӨӨГӨӨР ХАНГАХ

2020 онд Улсын бүртгэлийн хэлтэс нь иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын талаарх тоон мэдээг сар бүр нэгтгэн гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний бүртгэлийн газарт тогтмол хүргүүлж ажиллаа.

Сумдын улсын бүртгэгч нарын сарын мэдээ, тайланг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж байх, улсын бүртгэлийн мэдээллийн санд регистрийн дугаар буруу, овог, нэр, үсгийн зөрүүтэй иргэдийн зөрчлийг тухай бүр арилгаж дуусгах чиглэл өгч ажиллаж байна. Тухайлбал:

- ✓ 2020 оны байдлаар 2 иргэний регистрийн дугаарыг сольж ИУБ-25 маягтаар зөрчлийг арилгасан.
- ✓ Гэрлэлийн бүртгэлийн мэдээлэл ороогүй 18 иргэний ИУБ-15
- ✓ Нас баралтын бүртгэлийн мэдээлэл ороогүй 5 иргэний ИУБ-18 маягтыг тус тус нөхөн бичиж мэдээллийн санд оруулсан.
- ✓ Мэдээллийн санд үсгийн алдаатай болон мэдээлэл буруу орсон 110 иргэний мэдээллийн алдааг засуулахаар тухай бүр нь Иргэний улсын бүртгэлийн газарт шалгуулан зөрчлийг арилгасан.

Иргэний бүртгэлийн үйлчилгээнд гарч байгаа зөрчлийн дийлэнх нь 1988 оноос хойш төрсөн иргэдийн төрөлтийн мэдээлэлд эцэг, эхийн мэдээлэл үндсэн мэдээллийн санд тусгагдаагүй зэрэг зөрчлүүд эзэлж байна. Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасаг 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 01-ны өдрийг хүртлэх хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу 2020 оны 01 дүгээр сарын 02-оос 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрүүдэд 1 хаягт 10-

аас дээш тооны иргэн оршин суух бүртгэлтэй 77 хаягийн 1028 иргэний мэдээллийг нягтлан шалгаж тайланг ИУБГазарт хүргүүлж ажилласан.

2. Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг ээлжит сонгуулийн жилийн 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн түр зогсоож холбогдох арга хэмжээг авч тайланг ИУБГазарт хүргүүлсэн.

3. Өмнөговь аймгийн 15 сумын ИТХурлын Тэргүүлэгчдийн Хурлын сонгуулийн хэсэг байгуулж, нутаг дэвсгэр, төвийг батлах тухай тогтоолыг хуулийн хугацаанд хүлээн авч уг тогтоолыг үндэслэн 59 багийн 61 хэсгийн мэдээллийг цахим санд бүртгэсэн.

4. УБЕГазрын дэд даргын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь 2020 оны 05 дугаар сарын 18 ны өдөр УИХ-ын 11-р тойргийн 61 хэсэгт ажиллах 70 итгэмжлэгдсэн ажилтан, 4 албан хаагчдад хууль эрх зүйн сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулсан. Итгэмжлэгдсэн ажилтнуудтай ажил гүйцэтгэх гэрээг байгуулж төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг бүрэн гаргуулж авсан.

5. 2020 оны 05 дугаар сарын 27 ны өдөр Өмнөговь аймгийн 15 сумын 59 багийн 61 хэсгийн 45656 сонгогчийн нэрийн жагсаалтыг бүрэн хэвлэж, нэрийн жагсаалт тус бүрийг нэг бүрчлэн нягтлан шалгаж хэвлэсэн улсын бүртгэгч болон хэлтсийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан. 2020 оны 05 дугаар сарын 28 ны өдөр хөдөөгийн 14 сумын 51 хэсгийн хороонд 4 чиглэлийн дагуу Сонгогчдын нэрийн жагсаалт хүргэх албан хаагчдын тушаал, маршрутыг баталж, нэр хүргэх албан хаагчдад Сонгогчдын нэрийн жагсаалт болон хүлээлцэх актыг тус бүр 2 хувь хэвлэж хүлээлгэн өгсөн.

6. Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын баталсан хөтөлбөрийн дагуу 2020 оны 06 дугаар сарын 14,15 ны өдрүүдэд Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн 11 дүгээр тойргийн 61 хэсгийн хорооны санал авах байрны дэргэд ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтануудад 2 өдрийн сургалт зохион байгуулсан. Сонгогчийн нэрийн жагсаалтын цахим сангаас мэдээллийг нягтлан шалгаж программаас сонгогчдын нэрийн жагсаалтыг 3 хувь хэвлэж, баталгаажуулж ажилласан.

7. Өмнөговь аймгийн хэмжээнд 2020 оны 6 дугаар сард Сонгогчийн нэрийн жагсаалтын програмд санал авах байрны жагсаалтад бүртгэгдээгүй 37 хаяг, хэсэг оноогдоогүй 59 иргэн байсныг хаягийг бүртгэж хэсэг оноосон .

8. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйл, УБЕГазрын даргын 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” А/ 1168 тоот тушаалыг хэрэгжилтийг ханган 15 сумын улсын бүртгэгч нараар шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэрт “шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогсоосон” тухай тэмдэглэгээ хийлгэж ИУБ-22 маягтын хамт 2020 оны 08 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн хэлтэст хүлээн авч, хянан шалгасан.

9. Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгахтай холбоотой анхаарах асуудлуудын талаар улсын бүртгэлийн байгууллагын 61 итгэмжлэгдсэн 61 ажилтанд 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 09.00-12.30 цагт цахим хэлбэрээр сургалт зохион байгуулж төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг бүрэн гаргуулж авсан.

10. 2020 оны 09 дүгээр сарын 17 ны өдөр Өмнөговь аймгийн 15 сумын 59 багийн 61 хэсгийн 45290 сонгогчийн нэрийн жагсаалтыг бүрэн хэвлэж, нэрийн жагсаалт тус бүрийг нэг бүрчлэн нягтлан шалгаж хэвлэсэн улсын бүртгэгч болон хэлтсийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан. 2020 оны 09 дүгээр сарын 18-19 ны өдөр хөдөөгийн 14 сумын 51 хэсгийн хороонд 2 чиглэлийн дагуу Сонгогчдын нэрийн жагсаалт хүргэх албан хаагчдын тушаал, маршрутыг баталж, нэр хүргэх албан хаагчидад Сонгогчдын нэрийн жагсаалт болон хүлээлцэх актыг тус бүр 2 хувь хэвлэж хүлээлгэн өгсөн.

11. Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга болон Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн даргын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу Өмнөговь аймгийн УБХэлтэс нь 2020 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн итгэмжлэгдсэн ажилтанг хууль эрх зүйн мэдлэгээр хангах, сонгогчийн бүртгэлийг тулган шалгах, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг таньж оруулах, техник хэрэгсэл, программ хангамжтай ажиллах дадлага олгох сургалтыг 14 дүгээр тойргийн 61 хэсэгт ажиллах 61 итгэмжлэгдсэн ажилтан сургалтанд хамрагдаж Сонгогчдын нэрсийн жагсаалтыг цахим сангаас сонгогчийн хувийн мэдээллийг нягтлан шалгах программаас сонгогчдын нэрсийн жагсаалтыг хэвлэсэн.

12. 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр УБЕГазрын Архивын газраас зохион байгуулсан Иргэний бүртгэлийн лавлагааг олгоход анхаарах асуудлаар онлайн сургалт явуулж ИУБТасгийн бүртгэгч, архивч нар бүрэн хамрагдсан.

13. 2020 оны 11 дүгээр сарын 4-өөс, 2020 оны 11 дүгээр сарын 5-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойн баярын хүрээнд Ханбогд суманд “Улсын бүртгэлийн өдөрлөг” зохион байгуулж Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг 35 иргэнд үзүүлсэн.

14. 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Өмнөговь аймгийн Гашуун сухайт, Шивээ хүрэн боомтуудад үйл ажиллагаа явуулж байгаа 56 ХХК болон хувиараа нүүрс тээвэрлэлт явуулж буй нийт 348 жолооч нарын үндэсний энгийн гадаад паспортын зөрчилтэй болон хугацаа дууссан паспортын захиалгыг иргэдээс авч иргэний бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлийг хийж 2020 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Гашуун сухайт, Шивээ хүрэн боомтуудад захиалга өгсөн иргэдийн гадаад паспортыг олгосон.

15. Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагааг иргэдэд сурталчилах, ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор хэлтсийн мэдээллийн самбарт иргэний гэр бүлийн бүртгэлийн талаарх мэдээллийг сар бүр шинэчилж байршуулж, хэлтсийн вэб www.ubh.om.gov.mn сайтад сар бүрийн бүртгэлийн тоон мэдээллийг графикаар тухай бүр оруулсан.

ХОЁР. ИРГЭНИЙ ГЭР БҮЛИЙН БҮРТГЭЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТАЛААР

Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагааг явуулахдаа Гэр бүлийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллаа. Тайлангийн хугацаанд сумдаас ирүүлсэн иргэний гэр бүлийн бүртгэлийн үндсэн ИУБ маягт, шилжилт хөдөлгөөний ИУБ-22 маягыг хүлээн авч сүлжээнд шалган бичилтийн болон техникийн алдааг цаг тухайд нь залруулан засуулж сарын мэдээнд тусган баталгаажуулж сүлжээнд шивж оруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд :

1. Төрсний бүртгэл- 1680
2. Үрчилсний бүртгэл- 28
3. Ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний- 82
4. Эцэг /эх/ тогтоосны бүртгэл - 42

5. Гэрлэсний бүртгэл - 315
6. Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл- 75
7. Нас барсны бүртгэл - 345
8. Аймаг дотрох шилжилт хөдөлгөөн- 2261
9. Бусад аймаг хотоос шилжин ирсэн- 910 тус тус бүртгэгдсэн байна.

**2019 онд бүртгэгдсэн иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг
2020 онд бүртгэсэн бүртгэлтэй харьцуулсан үзүүлэлт**

Он	Төрсний	Гэрлэсний	Гэрлэлт дуусгавар болсны	Үрчилсний	Овог нэр өөрчилсний	Эцэг тогтоосны	Гэрлэлт сэргээсний	Нас барсны
2019 онд	1743	301	97	20	71	37	0	364
2020 онд	1680	315	75	28	82	42	0	345
Өсөлт бууралт	-63	14	-22	8	11	5	0	-19

**2019 онд бүртгэгдсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг
2020 онд бүртгэгдсэнтэй харьцуулсан үзүүлэлт**

Он	Бусад аймаг хотоос шилжин ирсэн	Аймаг дотор шилжин ирсэн
2019 онд	1369	3054
2020 онд	910	2261
Өсөлт бууралт	-459	-793

ГУРАВ. ҮНДЭСНИЙ ЭНГИЙН ГАДААД ПАСПОРТ ОЛГОЛТЫН ТАЛААР

2020 онд 722 иргэнээс шинээр гадаад паспорт олгох хүсэлтийн хүлээн авч , Монгол-Хятадын хил орчмын нутагт зорчих нэг удаагийн үнэмлэх 2, олон удаагийн

үнэмлэх 32 тус тус олгож, нийт 756 иргэнийг гадаадад зорчих эрхийн бүртгэлд бүртгэсэн.

2019 онд гадаад паспорт, хил орчмын нэг болон олон удаагийн үнэмлэх олголтын байдлыг 2020 онд олголтын байдалтай харьцуулсан үзүүлэлт

Он	Гадаад паспорт шинээр	Хил зорчих олон удаагийн үнэмлэх	Хил зорчих нэг удаагийн үнэмлэх
2019 онд	1936	557	83
2020 онд	722	32	2
Өсөлт бууралт	-1214	-525	-81

8.1. ДӨРӨВ. ИРГЭНИЙ БИЕИЙН ДАВХЦАХГҮЙ ӨГӨГДӨЛИЙН БҮРТГЭЛ БОЛОН ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХНИЙ БҮРТГЭЛ

2020 онд байдлаар нийт 3141 иргэний цахим үнэмлэх хүлээн авч иргэдийн гар дээр нийт 3014 иргэний цахим үнэмлэх олгогдоод байна.

Онлайн бүртгэлийн санд гэрлэлтийн бүртгэлийн мэдээлэл ороогүй 18 иргэний ХААТР-15, нас баралтын бүртгэлийн мэдээлэл ороогүй 5 иргэний ХААТР-18 маягтыг тус тус нөхөн мэдээллийн санд тусгасан. Регистрийн дугаарыг он зөрүүлж олгосон 2 иргэний эмнэлгийн байгууллагын тодорхойлолт, холбогдох бичиг баримтыг үндэслэн ХААТР-25 маягт бичиж мэдээллийг засварлаж зөрчлийг арилгасан.

Архивийн сангаас 320 иргэний хувийн хэрэг татан авч шалгаснаас зөрчилтэй иргэний мэдээллийг цаг тухайд нь Иргэний бүртгэлийн газарт албан тоот хүргүүлж зөрчлийг арилган буцаан байрлуулсан байна.

ТАВ. ИУБАРХИВААС ЛАВЛАГАА ОЛГОЛТ

Иргэний улсын бүртгэлийн архивын сангийн баяжилтанд орсон ИУБ маягтын тоон мэдээллийг сар бүр тогтмол гарган иргэний баримтын төв архивт хүргүүлсэн.

Иргэн , албан байгууллага, хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 4721 лавлагаа гаргаснаас иргэнд 4193, албан байгууллагад 299, албан хэрэгцээнд 229 тус тус олгосон байна.

ИУБ-11 1671, ИУБ-12 27, ИУБ-13 84, ИУБ-14 42, ИУБ-15 285, ИУБ-16 76, ИУБ-18 328, ИУБ-22 3171, ИУБ 31-3141, ИУБ-21 3100, нийт 11925 маягт архивт байрлуулж, архивийн баяжилтыг цаг тухайд нь бүрэн хийж ажилласан.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр давхардсан тоогоор 15000 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

3. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ

Нэг. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны бодлого төлөвлөлтийн хүрээнд

2020 онд Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагаанд Иргэний хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль болон холбогдох бусад хууль, Улсын бүртгэлийн ерөнхий газраас гаргасан шинээр мөрдөгдөж байгаа дүрэм, журмыг бүрэн хэрэгжүүлж газар, хэлтсийн даргаас өгсөн удирдамж чиглэлийн дагуу ажиллалаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн сарын мэдээг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газарт хуулийн хугацаанд хүргүүлэн газар, хэлтсийн дарга, холбогдох албан тушаалтнуудыг эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн холбогдох мэдээ, мэдээллээр хангаж ажилласан.

“Монгол улсад бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 80 жил”-ийн ойн хүрээнд Өмнөговь аймгийн дахь Улсын бүртгэлийн хэлтсээс зохион байгуулах ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ЭХЭУБТасгаас дараах ажлуудыг зохион байгуулж ажиллав. Үүнд:

1. Сумдын улсын бүртгэгч нарын ажлын байранд байршуулах ЭХЭУБ-ийн мэдээлэлийн самбарын эх бэлтгэж хэвлэлийн газарт хүргүүлсэн.

2. ЭХЭУБТасгийн архивт 2020 оны 11 дүгээр сарын 27, 28 ны өдрүүдэд архивын нягтруулсан шүүгээ хоёрыг нэмж байршуулан, хувийн хэргийн тооллого хийж, эх нотлох баримтыг шинэчлэн байршуулж их цэвэрлэгээ, ариутгал хийсэн.

3. Нийтийн орон сууцны жагсаалтыг мэдээллийн санд тулгаж ЭУБүртгэлийн дугааруудыг жагсаалтанд бичсэн.

4. Онлайн горимд холбогдсон Ханбогд суманд “Улсын бүртгэлийн өдөрлөг” зохион байгуулж 250 гаруй иргэн, хуулийн этгээдэд ЭХЭУБүртгэлийн үйлчилгээг газар дээр нь хүргэж өмчлөх эрхийн 59 гэрчилгээг олгосон.

2020 оны 4 дүгээр улиралд Улсын бүртгэлийн Ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуулийн 28 дахь

хэсэгт заасан нотлох баримтыг үндэслэн иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийн 850, ашиглах эрхийн 24 хүсэлтийг баталгаажуулан дугаар олгосон бөгөөд нийт 1409 эзэмших эрх, 40 ашиглах эрхийг бүртгэж А, Э дугаар олгосон байна.

Сумдын улсын бүртгэгч нарт ЭХЭУБүртгэлийн чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч газар өмчлөх эрхийн анхны бүртгэлийн мэдүүлэг 242, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэлийн мэдүүлэг 49-ийг хүлээн авч гэрчилгээг сумдын бүртгэгч нараар дамжуулан иргэдийн гарт хүргэсэн.

2020 оны дөрөвдүгээр улирлын байдлаар 8452 иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрх түүнтэй холбоотой бусад эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа.

Хоёр. Эд хөрөнгө өмчлөх эрхийг бүртгэж баталгаажуулах

2020 оны жилийн эцэст иргэн, хуулийн этгээдээс үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой бүртгэлийн мэдүүлэг **3063**, газар өмчлөх эрхтэй холбоотой бүртгэлийн мэдүүлэг **4258** нийт **7321** мэдүүлэг хүлээн авч хянан, холбогдох хууль тогтоомжийн дагуу эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэн түргэн, шуурхай явуулах эрх зүйн орчинг бүрдүүлэхэд шаардлагатай журам, заавар, зөвлөмж болон “Улсын бүртгэлийн ерөнхий хууль”, “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль” болон эрхийн улсын Ерөнхий бүртгэгчийн тушаалаар батлагдсан дүрэм, журмыг мөрдөн ажиллаж байна.

Эд хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэлд 1318 иргэний өмчлөх эрхийг баталгаажуулсанаас : Төрөөс үнэгүй хувьчилсан газар өмчлөх эрхийн бүртгэл 837, Төрөөс хувьчилсан орон сууцны анхны бүртгэл 4, Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэл 330, шинээр баригдсан орон сууцны анхны бүртгэлд 147,

Гэрээ хэлцэл нийт 5429 бүртгэгдсэнээс: Худалдах, худалдан авах гэрээ 1052, Бэлэглэх гэрээ 150, Арилжих гэрээ 32, Хамтран өмчлөгч өөрчлөгдөх 62, гэрээслэл болон өв залгамжлах эрхийн бүртгэл 90, Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл 2, Барьцааны гэрээтэй холбоотой бүртгэл 4036, бусад гэрээ 5 тус тус бүртгэсэн.

Эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт залруулгаар 320 бүртгэл бүртгэсэнээс:

Эд хөрөнгийн хаяг, хэмжээ, зориулалт өөрчлөх 210, эд хөрөнгийн үнэ, өмчлөгчийн овог нэр өөрчлөгдөх 37, өмчлөгчийн регистр өөрчлөгдөх 6, үрэгдүүлсэн болон гэмтээсэн гэрчилгээ дахин олгох бүртгэл 45, хувийн хэрэг хаах бүртгэл 22, тус тус бүртгэсэн байна.

Гурав. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх мэдээллийн сан болон нотлох баримтаар хувийн хэрэг бүрдүүлж, иргэн, хуулийн этгээд болон хууль хяналтын байгууллагыг ЭХЭУБүртгэлийн лавлагаа, мэдээллээр хангах

Шүүх, Цагдаа, Прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба болон бусад байгууллагад албан бичгээр эд хөрөнгө өмчлөх эрхтэй холбоотой 256 лавлагаа олгосон. Байгууллагыг төлөөлж эд хөрөнгийн маргаантай бүртгэлээр шүүх хуралд оролцоогүй. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар иргэн, хуулийн этгээдэд 279 лавлагаа олгосон.

Иргэн хуулийн этгээдээс хүлээн авсан эх нотлох баримтуудаар хувийн хэрэг үүсгэж газрын 14746 хувийн хэрэг, газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 7976 хувийн хэрэг, газар эзэмших эрхийн 1424 хувийн хэрэг, газар ашиглах эрхийн 40 хувийн хэрэг нийт **24171** хувийн хэрэг цаасан хэлбэрээр архивт хадгалдагдаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжаар нийт **103989829** төгрөгийг улсын төсөвт, тэмдэгтийн хураамжаар **4164036** төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого **293312189** төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус төвлөрүүлэн ажиллалаа.

4.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ

2020 онд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ажил, үйлчилгээг Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль, дүрэм, журам, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, чиглэлийг бүрэн хэрэгжүүлж, 2020 оны 12 сарын 07 өдрийн байдлаар нийт **2047** иргэн, хуулийн этгээдэд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн. Үүнд:

- ✓ Хуулийн этгээд нэрийн баталгаажуулалт - 299
- ✓ Шинээр үүсгэн байгуулсан хуулийн этгээд - 275

- Хязгаарлагдмал хариуцлагатай компани – 225
- Төрийн бус байгууллага /НҮТББ, ГҮТББ/ – 33
- Нөхөрлөл - 7
- Хоршоо – 2
- Үйлдвэрчний эвлэлийн байгууллага -1
- Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар- 2
- Төрийн байгууллага, албан газар - 5
- ✓ Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт - 875
- ✓ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгосон – 81
- ✓ Хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа олгосон - 162
 - Цахим сүлжээнээс - 136
 - Архивын хуулбар - 26
- ✓ Хуулийн этгээдийн хэлбэр өөрчилсөн – 1 тус тус бүртгэсэн.
- ✓ Хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавьсан - 6
- ✓ Хуулийн этгээдийн бүртгэлд хориг цуцалсан - 2
- ✓ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.3 т заасаны дагуу Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулах 38 хуулийн этгээдийн салбарыг бүртгэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны а/216 тоот тушаалаар батлагдсан “Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам”-ын дагуу 335 хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналтын дугаар олгож, 54 хуулийн этгээдээс тамга, тэмдэгийг хураан авч хүчингүй болгосон.

Тайлангийн хугацаанд шинээр байгуулагдсан 275 хуулийн этгээдийн, 875 хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн, лавлагааны эх нотлох баримт бичиг хураан авсан тамга тэмдгийг тус тус дүрэм журмын дагуу архивт хүлээлгэн өгч, цаасан баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна.

2020 оны 12 сарын 07-ны өдрийн байдлаар хуулийн этгээдийн бүртгэлийн бүх төрлийн үйчилгээний хураамж **24580000** төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Хуулийн этгээдийн бүртгэлийн хөдөлгөөний тоон мэдээ, архивын мэдээ, үнэт цаасны мэдээ, үйлчилгээний орлогын мэдээг сар бүрийн 25 ны өдрөөр гаргаж УБЕГазрын хуулийн этгээдийн газар, архивын газар, хэлтсийн нягтлан бодогчид тус тус хүргүүлэн ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд дараах ажил, үйлчилгээг гүйцэтгэсэн. Үүнд:

- 2020 оны 1 сард Төрийн жинхэнэ албан хаагчийн Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг шинэчлэн гаргаж улсын бүртгэлийн хэлтсийн даргад баталгааны хуудсыг хүргүүлсэн.
- Төрийн жинхэнэ албан хаагчийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулсан.
- 2020.01.17, 2020.01.24-ний өдрүүдэд 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн онлайн сургалтанд суусан.
- 2020 онд 3 удаа УБЕГазрын Хуулийн этгээдийн газраас зохион байгуулсан онлайн сургалтанд хамрагдсан.
- Төрийн жинхэнэ албан хаагчийн 2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлант хугацаанд өгсөн.
- 2020.06.14, 2020. 05.18 өдөр УИХурлын сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдсан онлайн болон танхимын сургалтанд хамрагдсан.
- Хуулийн этгээдийн ERS программаас хуулийн этгээдийн жагсаалтыг гаргаж 15 сумын улсын бүртгэгчид хүргүүлэн, бүрдүүлэх материал, бүртгэлийн талаар чиглэл зөвлөмж хүргэж ажилласан. 2020 оны 9 сарын 16-19, 11 сарын 05-06 ны өдрүүдэд хөдөөгийн 14 суманд зохион байгуулсан “Улсын бүртгэлийн өдөрлөг”-өөр хуулийн этгээдийн эцийн өмчлөгчийн мэдээлэл бүртгэх 335 баримт бичгийн хүлээн авч, зөвлөгөө мэдээлэл хүргүүлсэн. 2020 оны 12 сарын 07 ны өдрийн байдлаар 1032 хуулийн этгээдийн эцийн өмчлөгчийн мэдээллийг шинээр болон нөхөн бүртгэсэн.
- Хэлтсийн үйлчилгээний зааланд Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгүүлэх, тухай мэдээ, мэдээллийг хэвлүүлэн байршуулах
- 2020 онд 3 хуулийн этгээдийн бүртгэлийн зөрчил арилгуулахаар хяналтын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулж мэдээлэл зөрүүтэй бүртгэлийг засаж ажилласан.

5. ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ТАЛААР

Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээллийн технологийн ажилтан нь “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”, Монгол улсын Засгийн газраас баталсан “Мэдээлэл, сүлжээний аюулгүй байдлыг хангах” журмыг удирдлага болгон дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Мэдээлэл технологийн чиглэлээр

Иргэдэд үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалт болон шинэчлэгдсэн баримт бичгүүдийг хэлтсийн албан ёсны цахим хуудсандаа ойлгогдохуйц байдлаар байршуулсан.

Цахим хуудаст байгууллагын үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг цаг тухай бүрт нь байршуулсан ба цаг үе, үйл явдлын талаарх мэдээ 92, иргэд, аж ахуй нэгжүүдэд заавар зөвлөгөө өгсөн талаар бичлэг 82, иргэд аж ахуй нэгжүүдэд заавар зөвлөгөө өгсөн 53 мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудаст байршуулан ажиллаж байна.

Ажлын сул орон тооны зарыг цахим хуудсанд байршуулан зарын групп хуудсанд нийтлэн олон нийтэд нээлттэй зарлан ажилласан.

Баяндалай, Цогт-Овоо, Ноён, Сэврэй, Ханхонгор, Гурвантэс болон Даланзадгад сумын бүртгэгч нарын албан хэрэгцээнд ашиглаж байгаа хэвлэгч (принтер)-ийг шинээр солин бусад шаардлагатай тоног төхөөрөмжүүдтэй холбож хэвийн ажиллагаанд оруулсан.

Байгууллагын ашиглах хугацаа дууссан эд хөрөнгө, компьютер болон бусад тоног төхөөрөмжүүдийг актлах санал гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж, арга хэмжээг нь аван ажилласан.

Техник, тоног төхөөрөмжийн ашиглалтын дэвтэр-ийн загварыг гарган Улсын бүртгэлийн хэлтсийн даргаар батлуулан, ашиглалтын дэвтрийг хөтлөх ажлыг эхлүүлсэн.

Байгууллагын хөрөнгийн бүртгэлийг шинэчлэн, хэрэглэж байгаа хөрөнгө бүрт бүртгэлийн дугаарыг наан, давхцалгүйгээр шинээр бүртгэсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас хүргүүлсэн зөвлөмжийн дагуу цахим хуудсын ажиллагааг тогтворжуулж цаг үе, үйл явдлын мэдээг тухай бүрт нь байршуулж иргэдэд мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэх ажлыг хийж гүйцэтгэж байна. Орон нутаг дахь газар, хэлтсийн цахим хуудсыг нэгдсэн стандартад оруулах ажлын хүрээнд шинээр 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр цахим хуудас удирдах эрх нээгдсэн тул, 2020 оны 11 дүгээр сараас эхлэн шинэ домайн хаяг дахь цахим хуудсыг хөтлөн ажиллаж байна.

Хэлтсийн албан хаагчдын компьютер, тоног төхөөрөмжүүдийг эвдрэл гэмтэл гарсан үед цаг алдалгүй тухай бүрт нь засварлаж хэвийн ажиллагаанд ажиллуулж байна.

Байгууллагын дотоод сүлжээний ажиллах хэвийн байдлыг бүрдүүлэн сүлжээнд алдаа гарах, тасрах гэх мэт техникийн саатлуудыг тухай бүрт нь холбогдох арга хэмжээг аван ажиллаж байна.

2020 онд Улсын бүртгэлийн ерөнхий газраас цахим видео хурал, болон сургалтууд 30 орчим удаа хийгдэж цахим хурлыг тухай бүрт нь холбон техник төхөөрөмжийг хэвийн ажиллуулсан байна. Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь сумын улсын бүртгэгч нартайгаа цахим видео хурал болон сургалтыг 7 удаа амжилттай холбон ажилласан.

Улсын Их Хурлын сонгуулийн хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилчдад зориулсан хууль эрх зүй, арга зүйн сургалтыг цахим видео хэлбэрээр холбон ажилласан. Мөн “Ирц бүртгэлийн программын сургалт”-нд итгэмжлэгдсэн ажилчдад арга зүйн болон программын заавар зөвлөгөөг өгөн ажилласан.

Байгууллагын сүлжээний аюулгүй байдал, гадны халдлага, мэдээлэл алдагдхаас сэргийлэн арга хэмжээ авч ажиллан Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн заавар зөвлөмжийн дагуу сүлжээний хамгаалалтыг сайжруулж тохиргоог хийн ажиллаж байна.

Байгууллагын хяналтын камерын буланг гаргаж, шаардлагатай холболтуудыг шинэчлэн хийж, нэмэлт камер байршуулах шаардлагатай цэгүүдэд камерыг нэмэн холбож, утсаар давхар хянах боломжтой болгон ажиллаж байна.

Ил тод байдлын чиглэлээр

Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний талаархи мэдээг цаг тухай бүрт нь ТВ болон сайтаар хүргэж, 34 мэдээ мэдээллийг хэвлэж мэдээллийн самбарт байршуулсан.

Байгууллагын хийж гүйцэтгэсэн ажил, иргэдэд мэдээллэх шаардлагатай мэдээг цаг тухай бүрт нь цахим хуудсанд байршуулсан ба [facebook](#) хуудсанд 227 мэдээ тухай бүр тавигдсан.

Өргөдөл, гомдол хүлээн авах хариуцсан албан хаагчийн албан тушаал, овог нэр, харилцах утасны дугаар тодорхой бичиж цахим хуудсанд байршуулсан.

Сул орон тооны зарыг нийтэд зарлах, цахим болон мэдээллийн самбарт иргэдэд харагдахуйц байршуулсан ба нийт 6 сул орон тооны зарыг байршуулан ажиллаж байна.

COVID-19 вирус дэлхий даяар тархсантай холбоотойгоор байгууллагын цахим хуудсаар мэдээ мэдээлэл 18, заавар зөвлөмж 45 (үүнээс бичлэгээр 20) дамжуулан иргэдэд хүргэсэн байна.

Бусад ажлын чиглэлээр

Байгууллагын эвдэрч засах шаардлагатай эд зүйлсийг тухай бүрт зассан. Мөн байгууллагын серверийн өрөөн доторх эд зүйлийг цэгцэлж хэрэггүй ашиглагдах боложгүй болсон эд зүйлсийг устгалд оруулсан. Байгууллагын серверийн өрөөнд хяналтын камерын булан гаргаж, тохижуулсан.

Байгууллагаас зохион байгуулж байгаа хамт олны ажилд идэвхи санаачлагатай оролцон ажиллаж байна.

Няравын ажил үүргийг давхар эрхэлж байгаа тул сар бүрийн үнэт цаасны мэдээг нэгтгэх, шаардлагатай үнэт цаасыг захиалах, бичиг хэргийн холбогдолтой зүйлсийг цуглуулах, зөв хувиарлах ажлуудыг хийж байна.

Мөн удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг цаг тухай бүрт нь хийж гүйцэтгэж байна.

6. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР

2020 онд Хяналтын улсын байцаагчаас Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журам болон бусад холбогдох хууль тогтоомж, журмыг сурталчилан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. Мөн хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг улирал, хагас, бүтэн жилээр гарган хэлтсийн даргаар баталгаажуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна

Байнгын хяналтыг иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, архив, мэдээллийн технологийн аюулгүй байдлын чиглэлээр хийсэн.

ИУБүртгэл: Зөрчлийн тухай хуулийн 15.24.1, 15.24.2, 15.24.4, 10.20.1, 15.23.1.1 дүгээр зүйлийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг нийт 508 иргэн, хуулийн этгээдэд нийт 14 055 000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Үүнээс:

- Иргэний үнэмлэх сунгалтын хугацаа хэтрүүлсэн 256 иргэнийг 5 120 000 төгрөгөөр,
- Иргэний цахим үнэмлэх үрэгдүүлсэн 242 иргэнийг 7 260 000 төгрөг,
- Иргэний цахим үнэмлэх гэмтээсэн 7 иргэнийг 175 000 төгрөг
- Хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтөө хуулийн хугацаанд бүртгүүлээгүй 2 компанийг 1 000 000, тамга тэмдгээ үрэгдүүлсэн 1 компанийг 500 000 төгрөгөөр тус тус торгож, тухай бүрт нь аймгийн Хяналтын прокурор Д.Мөнхтуяа, Г.Ганбаяр нарт хянуулж холбогдох зөвлөгөө мэдээлллийг авч, хамтран ажилласан. Мөн шийтгэлийн хуудасны зарцуулалтын тайланг сар бүр гаргаж ахлах нягтлан бодогчид хүлээлгэн өгсөн.

Иргэний баримт бичгийн зөрчлөө арилгуулах өргөдөл гаргасан 35 иргэний дүгнэлтийг Хяналт, шалгалтын газарт хүргүүлж, online програмд баталгаажиж бүрэн шийдвэрлэсэн. Хяналтын улсын байцаагчийн хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу хөдөөгийн 14 сумын 2019 онд бүртгэсэн иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэлийн нийт 4574 материалд хяналт, шалгалт хийхэд ноцтой зөрчил дутагдал илрээгүй бөгөөд иргэний цахим үнэмлэхний хүчинтэй

хугацааг нягтлан шалгах, өргөдлийн огноо, толгойг зөв бичүүлж байх, хураан авч, хувийн хэргийн эх нотлох баримтанд хавсаргасан гэрчилгээг хүчингүй болгож байх тал дээр нийт бүртгэгч нарт 2020 оны 03 дугаар сарын 24-нд зөвлөмж хүргүүлсэн. Тайлант хугацаанд шилжилт хөдөлгөөний бүртгэл, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэлийн бүрдүүлбэр материалын нийт 6618 бүртгэлд хяналт шалгалт хийхэд зөчил дутагдал илрээгүй. Хяналт шалгалтын газрын 2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 8/7215 тоот чиглэлийн хүрээнд Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасны дагуу шилжилт хөдөлгөөний бүртгэлийг санал авах өдрөөс 60 хоногийн өмнө Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” А/1168 дугаар тушаал гарсантай холбогдуулан шилжилт хөдөлгөөний бүртгэлийн нотлох баримтыг хянаж, эх нотлох баримт болон ИУБ-22 маягтыг тулган шалгаж иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хуулийн хугацаанд үнэн зөв шивж, баталгаажуулсан. Мөн 15 сумын улсын бүртгэгч нараар шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэрт “шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогсоосон” тухай тэмдэглэгээ хийлгэж, ИУБ-22 маягтын хамт 2020 оны 08 дугаар сарын 15, 16 ны өдрүүдэд УБХэлтэст ирүүлснийг лацдаж, Иргэний улсын бүртгэлийн архивт хадгалсан. Тус аймагт бүртгэгдсэн нийт 959 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн бүрдүүлбэр материалыг тухай бүр нягтлан шалгаж Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн. Мөн Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 14 дүгээр тойргийн 61 хэсгийн сонгогчийн нэрийн жагсаалт хэвлэх үйл явцад хяналт шалгалтыг хийж ажилласан.

ХЭУБүртгэл: Хуулийн этгээдийн оноосон нэрийн бүртгэл, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ERS програмд хандах эрхийн дагуу орж бүртгэлүүдийг өдөр тутам хянаж байна. Тайлангийн хугацаанд шинээр үүсгэн байгуулагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон нийт 154 бүртгэлийн бүрдүүлбэр материалын архивын хувийн хэрэг дэх эх нотлох баримтыг татан авч шалгахад зөрчил дутагдал илрээгүй, бүгд бүртгэлийн бүрдүүлбэр хангасан нотлох баримтууд байсан.

Хуулийн этгээдийн цахимжуулалтад бүртгэгдээгүй “Онилэцмэт”НҮТББ-н бүртгэлийг шалгахад Өвөрхайнгай аймаг нь 2018 онд хуулийн этгээдийн архивын

нотлох баримтыг цахимжуулах явцдаа уг НҮТББ-ийн 8000018 регистрийн дугаараар “Энх итгэлийн гэгээ” гэсэн оноосон нэртэй НҮТББ-ийг андуурч буруу цахимжуулсан. Мөн “Онилэцмэт”НҮТББ нь 2009 онд байгуулагдсан Улаанбаатар хотын үйлдвэрчний эвлэлийн хороотой 8000018 регистрийн дугаар давхардсаныг “Онилэцмэт” НҮТББ-н үүсгэн байгуулагч, удирдах зөвлөлийн даргатай холбогдож Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу сонсох ажиллагааг явуулж, УБЕГазрын Хяналт шалгалтын газарт тайлбарыг хүргүүлсэн. Хуулийн этгээдийн тамга тэмдгээ хаяж үрэгдүүлсэн “Орших нутаг”ХХК-г зөрчлийн тухай хуулийн 10.20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 500 нэгжээр, үүсгэн байгуулагч хувьцаа эзэмшигчийн өөрчлөлтөө хуулийн хугацаанд бүртгүүлээгүй “Монос Өмнөговь”ХХК-г зөрчлийн тухай хуулийн 15.23 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт зааснаар 500 нэгжээр тус тус торгож, дүгнэлтийг үйлдэн хяналт шалгалтын газарт хүргүүлэн зөрчлийг бүрэн арилгасан. Мөн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн 70 бүртгэлд хяналт шалгалтыг хийхэд зөрчил дутагдал илрээгүй.

“Сод номгон”ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхдээ хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд хувьцаа эзэмшигч 2 иргэнийг 1 болгох бүртгэлийг бүртгээгүй зөрчилд, мөн хуулийн этгээдийн тамга тэмдгээ хаяж үрэгдүүлсэн “Натурал морнинг”ХХК-г зөрчлийн тухай хуулийн 10.20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 500 нэгжээр торгон, хуучин хяналтын дугаарыг хүчингүй болгосон дүгнэлтийг тус тус үйлдэж Хяналт шалгалтын газарт хүргүүлэн зөрчлийг бүрэн арилгасан.

ЭХЭУБүртгэл: ЭХЭУБүртгэлийн ePRS програмд хандах эрхийн дагуу орж бүртгэлийн бүрдүүлбэр материалуудыг түүвэрчлэн шалгаж байна. Тайлангийн хугацаанд газар өмчлөх эрхийн бүртгэл, барьцаат зээлийн гэрээ, БЗГэрээ дуусгавар болгосон, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэлийн нийт 581 бүртгэлийн бүрдүүлбэр материалыг шалгахад ямар нэгэн зөрчил дутагдал илрээгүй.

Эрхийн улсын бүртгэлийн Г-1105000298, Г-1103000001 дугаартай бүртгэлүүдэд буруу цахимжсан барьцаат зээлийн гэрээний зөрчлийг арилгахаар хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үйлдэж Хяналт, шалгалтын газарт хүргүүлэн, зөрчлийг арилгасан.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналтын улсын байцаагчийн 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 25 тоот албан шаардлага, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 7/1960 тоот чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн дагуу Өмнөговь аймагт бүртгэлтэй газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх төлөвтэй 7 бүртгэл, өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсэх төлөвтэй 8 бүртгэл, төрөөс хувьчилсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэх төлөвтэй 2 бүртгэл, шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэх төлөвтэй 97 нийт 114 бүртгэлийг бүртгэхдээ мэдээллийн санд газрын нэгж талбарын дугаар тусгаагүй бүртгэсэн, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 7/9562 тоот чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн дагуу бүртгэлийн төрлийг буруу сонгосны улмаас Төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг төрөөс хувьчилсан орон сууцны өмчлөх эрхийг анх удаа бүртгэх төлөвтэй 19 бүртгэл, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг бүртгэх төлөвтэй 3 бүртгэл, төрөөс хувьчилсан орон сууцны өмчлөх эрхийг төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх төлөвтэй 4 бүртгэл нийт 26 бүртгэлийн төрлийг буруу сонгосон зөрчилтэй бүртгэлүүдэд хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үйлдэж Хяналт, шалгалтын газарт хүргүүлэн, зөрчлийг арилгаж бүрэн шийдвэрлэсэн. Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээг хаяж үрэгдүүлсэн эрхийн улсын бүртгэлийн Г-1105005072, Ү-1105001234, Г-1105000103, Г-1105003532, Г-1105003534, Г-1105003535, Ү-1113000031, Ү-1105003562 дугаартай бүртгэлүүдэд хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үйлдэж Хяналт, шалгалтын газарт хүргүүлэн, зөрчлийг арилгасан.

Бусад:

- 2020 оны 01 дүгээр сарын 08-нд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг чиглэлээр аймгийн ГХБХБГазар, Улсын бүртгэлийн хэлтсийн хамтарсан уулзалтад оролцсон.
- 2020 оны 03 дугаар сарын 06-нд УБЕГГазрын Иргэний бүртгэлийн газраас зохион байгуулсан "Монгол улсын сонгуулийн хууль"-ийн талаарх online сургалтанд хамрагдсан.

- 2020 оны 03 дугаар сарын 16-нд Олон улсын хэрэглэгчийн өдрийг тохиолдуулан “Зөрчлийн хууль”-ийн талаар олон нийтийн цахим сүлжээгээр иргэдэд мэдээлэл хүргэсэн.
- 2020 оны 03 дугаар сарын 23-нд УБЕГазрын ЭХЭУБүртгэлийн газраас зохион байгуулсан online сургалтанд хамрагдсан.
- 2020 оны 04 дүгээр сарын 08-нд УБЕГазраас зохион байгуулсан Сонгуулийн хуулийн талаарх сургалтанд хамрагдсан.
- 2020 оны 04 дүгээр сарын 14,15-нд Улсын бүртгэлийн байгууллагын удирдах ажилтны сургалтанд хамрагдсан.
- 2020 оны 04 дүгээр сарын 15-нд Өмнөговь аймгийн 15 сумыг холбосон online сургалтанд оролцож, улсын бүртгэгч нарт мэдээлэл хүргэсэн.
- 2020 оны 04 дүгээр сарын 22-нд УБЕГазрын Иргэний бүртгэлийн газраас зохион байгуулсан Иргэний улсын бүртгэлийн системийн талаарх сургалтанд хамрагдсан
- 2020 оны 05 дугаар сарын 06-08, 13-15 ны өдрүүдэд УБЕГазрын Хяналт шалгалтын газраас Хяналтын улсын байцаагч нарт зориулсан online сургалтанд хамрагдаж, дүгнэлт боловсруулж дадлага ажил хийсэн.
- 2020 оны 05 дугаар сарын 08 нд иргэн Б.Амаржаргалын нэхэмжлэлтэй гэрлэлтийн бүртгэлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах тухай иргэний хэргийн анхан шатны шүүх хуралд байгууллагыг төлөөлж гуравдагч этгээдээр оролцсон.
- 2020 оны 05 дугаар сарын 14 нд Насан туршийн боловсролын төвөөс зохион байгуулсан Угийн бичгийн талаарх танхимын сургалтанд хамрагдсан.
- 2020 оны 05 дугаар сарын 15 нд УБЕГазраас зохион байгуулсан МУИХурлын Сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх цахим сургалтанд хамрагдсан.
- 2020 оны 05 дугаар сарын 18 нд Улсын бүртгэлийн байгууллагын Сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан цахим сургалтанд хамрагдсан.
- 2020 оны 05 дугаар сарын 26 нд УБЕГазраас зохион байгуулсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цахим сургалтанд хамрагдсан.
- Өмнөговь аймгийн Прокурорын газарт хяналт шалгалтын чиглэлээр хамтран ажиллах албан тоотыг хүргүүлж, батлагдсан удирдамжийн дагуу Прокурорын газрын хяналтын прокурор, хууль цаазын дэд зөвлөх Г.Ганбаяр, Мэргэжлийн хяналтын газрын хүнсний чанар стандартын хяналтын улсын байцаагч М.Туяацэцэг нарын хамтаар 2020 оны 05 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд

Өмнөговь аймагт хүнсний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, хүнсний аюулгүй байдлыг хангуулах, иргэний үнэмлэх, энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээг барьцаалсан, барьцаалуулсан зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, зөвлөгөө мэдээлэл хүргэх зорилгоор хяналт шалгалтыг хийхэд иргэн С.Нарантуяа /км71022462/, Э.Ууганцэцэг /кю88040263/ нар нь “Сүрлэг гурван хайрхан”ХХК-н Хүлэг дэлгүүрт, иргэн Т.Оюунтуяа /кв83101801/ нь “БЭТБ”ХХК-н Түвшин дэлгүүрүүдэд тус тус иргэний үнэмлэхээ барьцаалуулсан, барьцаалсан зөрчлийг илрүүлж иргэний үнэмлэхийг хураан авч акт үйлдсэн. Зөрчил үйлдсэн “Сүрлэг гурван хайрхан”ХХК-н Хүлэг дэлгүүрийн худалдагч Номин-Эрдэнэ, “БЭТБ”ХХК-н Түвшин дэлгүүрийн худалдагч Батсайхан нарт Монгол улсын зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 2 дахь заалт “Иргэний үнэмлэх, энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээг барьцаалсан, барьцаалуулсан, зориуд гэмтээсэн бол хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн хуулийн зүйл заалтыг уншиж сонсгон хариуцлага тооцох болохыг мэдэгдэж, алдаа дутагдлыг дахин давтахгүй байх чиглэл зөвлөмжийг хүргүүлэн, зөрчлийг хуулийн хугацаанд шалган шийдвэрлэсэн.

- 2020 оны 06 дугаар сарын 14,15-ны өдрүүдэд Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн 11 дүгээр тойргийн 61 хэсгийн хорооны санал авах байрны дэргэд ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтануудад зориулсан эрх зүйн болон програмын 2 өдрийн сургалтанд бүрэн хамрагдсан.
- 2020 оны 08 дугаар сарын 11 нд УБЕГазрын Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан ЭХЭУБүртгэлийн талаарх online сургалтанд хамрагдсан.
- 2020 оны 09 дүгээр сарын 10 нд Ёс зүйн хорооноос зохион байгуулсан “Төрийн албаны шинэтгэл-Ёс зүй хандлага” сэдэвт online сургалтанд хамрагдсан.
- 2020 оны 09 дүгээр сарын 14 нд Улсын бүртгэлийн хэлтсээс зохион байгуулсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн талаарх танхимын сургалтанд хамрагдсан.
- 2020 оны 09 дүгээр сарын 24-нд УБЕГазраас зохион байгуулсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн талаарх цахим сургалтанд хамрагдсан.

- 2020 оны 10 дугаар сарын 15 нд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 14-р тойргийн 7 дугаар хэсгийн хороонд Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаар ажилласан.
- 2020 оны 11 дүгээр сарын 05, 06 нд Ханбогд суманд зохион байгуулагдсан **“Улсын бүртгэлийн өдөрлөг”**-ийн хүрээнд 200 гаруй иргэнд зөвлөгөө мэдээллийг хүргэсэн.

УДИРДЛАГЫН БАГТ ТАВИХ САНАЛ:

➤ Хавар, зуны улиралд хэлтсийн гадна талбайд тарьсан 320 мод услахад усны үнэ хүрэлцэхгүй байгааг судлан үзэж арга хэмжээ авч өгнө үү.

➤ 2021 онд хэвлэл мэдээллийн зардал төсөвлөх

➤ Улсын бүртгэлийн ерөнхий хуулинд Улсын бүртгэлийн байгууллагыг “Улсын онцгой объект” гэж заасан ч төрийн тусгай хамгаалалтанд байх объектод ороогүй учир цагдаагийн байгууллагын харуул хамгаалтанд орох боломжгүй. УБЕГ-ын даргын тушаалаар батлагдсан аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн бүтэц, орон тоогоор 4 гэрээт албан хаагч ажиллуулж байгаа нь /жижүүр 2, үйлчлэгч 2/ болзошгүй эрсдэлд сөрөг үр дагавар гарах магадлалтай байдаг тул жижүүрийн орон тоог Төрийн үйлчилгээний ажилтан болгох

➤ ЭХЭУБТасгийн архивт үл хөдлөх хөрөнгийн **6847**, газар өмчлөх бүртгэлийн **13051** хувийн хэрэг байрлаж байгаа бөгөөд өдөр тутмын бүртгэл болон барьцаат зээлийн гэрээ харьцангуй их бүртгэгддэг тул аймгуудын ЭХЭУБүртгэлд орон тооны зураг авалт хийж, ЭХЭУБТасагт улсын бүртгэгчийн орон тоог 1 нэмэгдүүлэх

➤ УБЕГазрын орон нутаг дахь Улсын бүртгэлийн хэлтэст орон тооны нярав байхгүйгээс шалтгаалж санхүүгийн үйл ажиллагаанд хүндрэл гардаг тул няравыг орон тооны болгох

➤ Хяналт-шинжилгээний ажилтны орон тоог шинээр нэмэх

➤ 2021 онд Улсын бүртгэгч нарыг чадавхижуулах зорилгоор УБЕГазар Удирдлагын академитай хамтран богино хугацааны /3-7 хоногийн/ танхимын сургалт зохион байгуулах

2021 ОНЫ ЗОРИЛТ

✓ 2021 оны Монгол улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг хариуцлагатай зохион байгуулах.

✓ Сүлжээ компаний шилэн кабел татаагүй байгаа Ханхонгор, Цогтцэций, Гурвантэс, Цогт-Овоо, Ноён, Сэврэй сумдын шилэн кабелийн асуудлыг УБЕГазрын удирлагад танилцуулж шийдвэрлүүлэх

✓ Сумдын улсын бүртгэгч нарын ажил, үйлчилгээнд хяналт, шалгалтыг хуваарийн дагуу хийж гүйцэтгэх

✓ Архивын эх нотлох баримтын бүрэн бүтэн байдал, аюулгүй хэвийн ажиллагааг тогтмол хангах

✓ Байгууллагын болон Улсын бүртгэлийн архивын, Мэдээллийн технологийн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах

✓ Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах

✓ Албан хаагчдын сахилга хариуцлагыг нэмэгдүүлж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах

✓ Өмнөговь аймгийн 2021-2025 оны үндсэн чиглэлд Улсын бүртгэлийн цахим бүртгэлийг нэвтрүүлэх зардалд 62 700 000 төгрөг төсөвлүүлж, аймгийн ИТХурлын 2 дугаар хуралдаанаар батлуулсан.

**Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн
2020 оны жилийн эцсийн тайлан гаргасан**

1. Ч.Энхмөнх - Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
2. Д.Наранбилэг - Хяналтын улсын байцаагч
3. Б.Должинсүрэн - ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч
4. Б.Азжаргал - ЭХЭБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч
5. З.Хасар - Иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч
6. Ч.Пүрэвдавга - Иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч
7. Т.Нямсамбуу - ЭХЭБТасгийн улсын бүртгэгч
8. М.Оюун-Эрдэнэ - ЭХЭБТасгийн улсын бүртгэгч.
9. М.Энхтогтох - Хуулийн этгээдийн улсын бүртгэгч
10. С.Батхүү - Ахлах нягтлан бодогч
11. А.Цэцэгдэлгэр - ИБТасгийн архивчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
12. А.Цэцэгжаргал - ЭХЭБТасгийн архивч
13. С.Ариунсайхан - Даланзадгад сумын улсын бүртгэгч
14. М.Түвшинжаргал - Даланзадгад сумын улсын бүртгэгч
15. О.Эрдэнэбат - Мэдээллийн технологийн ажилтан, нярав
16. Сумын 14 улсын бүртгэгч

ТАЙЛАНГ НЭГТГЭЖ ХЯНАСАН:

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Ч.ЭНХМӨНХ